

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

|   |  |    |
|---|--|----|
| 1 | Аудитын гэрчилгээ .....  | 2  |
| 2 | Аудитын тайлан.....  | 4  |
|   | 2.1. Оршил.....  | 4  |
|   | 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....   | 4  |
|   | 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....   | 4  |
|   | 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....  | 5  |
|   | 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 5  |
|   | 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....   | 5  |
|   | 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....  | 5  |
|   | 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....   | 6  |
|   | 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....  | 7  |
|   | 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....  | 7  |
|   | 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                 | 9  |
|   | 2.12. Шилэн дансны мэдээлэл .....  | 9  |
|   | 2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....   | 9  |
|   | 2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....   | 10 |
| 3 | Менежментийн захидал.....  | 11 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан.....  | 14 |
|   | 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....   | 14 |
|   | 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....  | 16 |
| 5 | Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....  | 24 |

## Товчилсон үгийн жагсаалт

|             |   |
|-------------|---|
| УСНББОУС    | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт                     |
| АДБОУС      | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт                                   |
| НББОУС      | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт                                    |
| БСШУСЯ      | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам                                     |
| ТБОНӨХБАУХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах |
| ШУТИС       | Шинжлэх ухаан, технологийн их сургууль  |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/823  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

ШУТИС-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ректор Б.Очирбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн тендерийн баримт бичгийг иж бүрэн, зохистой бүрдүүлэх, ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэх, “Дотоод аудитын дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ШУТИС-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

ШУТИС-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

ШУТИС-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 6-аас 2020 оны 3 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Грант Торнтон аудит” ХХК-ийн аудитор Г.Батхишиг, аудитор Б.Буянтэгш, туслах аудитор Б.Отгонтэнгэр, туслах аудитор Д.Сарангуа, туслах аудитор Ш.Долгоржав нар хариуцаж хэрэгжүүлэв.

ШУТИС-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 5/96 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Тус сургууль нь нэр хүндээ тогтвортой өсгөж азийн шилдэг их сургуулиудын нэг болох зорилго тавин ажиллаж байна.

Уг зорилтын хүрээнд 2019 онд дараах ажлыг хийжээ. Тухайлбал:

- ШУТИС-д чанарын удирдлагын ISO-9001-2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн;
- “QS show case 2019” сэтгүүлд ШУТИС-ийн тухай мэдээллийг хэвлүүлсэн;
- ШУТИС-ийн түүхт ойг угтаж 60 “ҮНДСЭН СУРАХ БИЧИГ”-ийг шинээр бүтээн хэвлүүлсэн;
- “Тогтвортой хөгжилд дээд боловсрол-дэвшилтэт технологийн үүрэг, ач холбогдол сэдэвт олон улсын форумыг гадаадын 24 их сургуулийн захирлууд, төлөөлөгчид дунд зохион байгуулсан;
- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн М.Өсөхбаяр ахлагчтай “Mongolia-I” баг Монгол улсад анх удаа зохион байгуулсан “ABU ROBOCON 2019 Ulaanbaatar” олон улсын роботын тэмцээний дэд байранд шалгарсан байна;
- Удирдах зөвлөлийн шийдвэрээр Бизнесийн ахисан түвшний сургуулийг бие даасан бүрэлдэхүүн сургууль болгожээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн заавар, журам, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Шинжлэх ухаан технологийн их сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “U-Finance 3.0” программ хангамжийг ашигладаг байна.

ШУТИС-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн бөгөөд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 57,821.8 сая төгрөгийн 1.0 хувиар тооцон 578.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

ШУТИС-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,805.6 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт         |
|---|------------------|------------------|------------------|
| Мөнгөн хөрөнгө                                    | 34,413.1         | 24,657.1         | (9,756.1)        |
| Авлага  | 6,015.2          | 2,863.3          | (3,151.9)        |
| Урьдчилгаа  | 765.6            | 665.6            | (99.9)           |
| Бараа материал                                    | 1,898.4          | 1,900.1          | 1.7              |
| Үндсэн хөрөнгө                                    | 93,435.1         | 104,671.5        | 11,236.5         |
| Биет бус хөрөнгө                                  | 7,552.7          | 7,517.1          | -35.8            |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>144,080.1</b> | <b>142,274.4</b> | <b>(1,805.6)</b> |
| Богино хугацаат өр төлбөр                         | 10,206.1         | 11,411.7         | 1,205.6          |
| Урт хугацаат өр төлбөр                            | 67.1             | 61.4             | (5.7)            |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 30,748.3         | 30,748.3         | -                |
| Хуримтлагдсан үр дүн                              | 41,942.6         | 38,942.6         | (3,000.0)        |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                  | 61,115.8         | 61,110.4         | (5.4)            |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>144,080.1</b> | <b>142,274.4</b> | <b>(1,805.6)</b> |

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүн дансанд материаллаг хэмжээний дараах өөрчлөлтүүд гарсан байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан шалтгаан нь 2018 оны сүүлийн хагас буюу 2018-2019А улиралд шинээр элссэн оюутны тоо 4316, нийт сонгон суралцсан кредит 274,339 байсан бол тайлант онд шинээр элссэн оюутны тоо 1905, нийт сонгон суралцсан кредит 222,448 бол өмнөх оноос 2411 оюутан, 51,850 кредитээр буурсан нь гол нөлөөлсөн байна.
- Авлага дансны үлдэгдэл буурсан нь БСШУСЯ-аас авах тогтмол зардлын санхүүжилтийн 2,639.1 сая төгрөгийн авлагыг ТУЗ-ийн 2020 оны 01-р сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолоор найдваргүй авлагаар тооцож данс бүртгэлээс хассан. Мөн сургалтын төлбөрийн болон бусад авлагыг барагдуулах талаар олон ажлууд хийгдсэн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,236.5 сая төгрөгөөр өссөн нь 2019 онд 9,160.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан ба Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам хэрэгжүүлж байгаа “Дээд боловсролын шинэчлэл”, “Инженер, технологийн дээд боловсрол” төслүүдийн санхүүжилтээр сургалтын орчныг сайжруулах лабораторийн тоног төхөөрөмж, мөн хамтын ажиллагаатай ажилладаг Япон улс Нагоя их сургууль, БНСУ-ын Санмён их сургууль зэрэг байгууллагаас хандив тусламжаар нийт 7,603.6 сая төгрөгийн хөрөнгө авсантай холбоотой байна.
- Богино хугацаат өр төлбөр 1,205.6 сая төгрөгөөр өссөн нь шинээр ашиглалтад орсон “Хичээлийн 8-р байр”-ны гүйцэтгэлийн баталгаа (5%)-тай холбоотой 445.2 сая төгрөгийн өглөг, 2018 оноос төсөл гэрээт ажлын орлогыг аккруэл сууриар бүртгэж эхэлсэнтэй холбоотойгоор урьдчилж орсон орлого 2,003.1 сая төгрөгийг орлого хүлээн зөвшөөрснөөс хамааралтай ба сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого 1,528.9 сая төгрөгөөр буурсан байна.
- Хуримтлагдсан үр дүн буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл, авлага, түр сургалт, төсөл, гэрээт ажлын урьдчилж орсон орлогын залруулга, өмнөх жилүүдэд ашиглалтад тавьж олгосон бараа материалын зардал зэрэг нийт 1,768.8 сая төгрөгийг бүртгэсэн, БСШУСЯ-наас авах тогтмол зардлын санхүүжилтийн 2,639.1 сая төгрөгийн авлагыг Удирдах

зөвлөлийн 2020 оны 1-р сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолоор найдваргүй авлагын зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

ШУТИС-ийн Ректор (төсвийн захирагч) нь БСШУСЯ-ны Сайд (төсвийн ерөнхийлөн захирагч)-тай “Үр дүнгийн гэрээ” байгуулан ажилладаг. Иймд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Шинжлэх ухаан технологийн их сургууль тайлант онд 46,250.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 49,175.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 106.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

| Орлогын төрөл                         | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Зөрүү          | Хувь  |
|---------------------------------------|-----------------|-----------------|----------------|-------|
| Улсын төсвөөс санхүүжих               | 2,447.1         | 446.4           | 2,000.7        | 18.2  |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих        | 98.1            | 129.2           | 31.2           | 131.9 |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 43,704.4        | 48,599.3        | 4,895.1        | 111.2 |
| <b>Нийт дүн</b>                       | <b>46,249.6</b> | <b>49,175.1</b> | <b>2,925.4</b> |       |

Нийт төвлөрүүлэх орлого 2,925.4 сая төгрөгөөр давсан нь төсөл, гэрээт ажлыг төлөвлөснөөс илүү хийж гүйцэтгэснээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх оюутны болон бусад сургалт арга хэмжээнд зориулан 62,965.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 53,332.1 сая төгрөгийг урсгал зардалд, 9,632.8 сая төгрөгийг хөрөнгө худалдан авахад зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Их дээд сургуулиудын ашиглалтын зардлыг улсын төсвөөс хариуцдаг байсан ба 2018 оноос уг санхүүжилтийг зогсоосон тул улсын төсвийн санхүүжилт 1,976.1 сая төгрөгөөр тасарсан.

Төсөл гэрээт ажлын зардал 164.9 сая төгрөгөөр хэтэрсэн нь төлөвлөснөөс илүү ажил гүйцэтгэсэнтэй холбоотой.

Хөрөнгө оруулалтын 84 төсөл, арга хэмжээнд 9,632.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 8,003.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 58,931.1 сая төгрөг буюу 93.6 хувьтай байгаа нь батлагдсан хөрөнгө оруулалтыг хэмнэж зарцуулсантай холбоотой юм.

## 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 351.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 189.5 сая төгрөгийн алдааг залруулж, 161.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, хууль, дүрэм журмыг дагаж мөрдөөгүй алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулсан 189.5 сая төгрөгийн 5 алдааг дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна. Үүнд:



1. Мэргэшил дээшлүүлэх (Мэргэшсэн төсөвчин, инженер, зөвлөх инженер бэлтгэх, холбогдох тушаал шийдвэр 2019 онд гарсан) түр сургалтын төлбөрийн орлого 127.6 сая төгрөгийг тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалт, УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ын 7 дугаар заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Япон улсын Шима Секи компанитай 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан тоног төхөөрөмж худалдан авах гэрээний дагуу үүссэн гадаад валютаарх өр төлбөрийг тайлант хугацааны эцэст ханшийн тэгшитгэл хийж, 36.4 сая төгрөгийн валютын ханшийн зөрүүний гарзыг бүртгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

3. Бүрэлдэхүүн сургуулиудын балансад илэрхийлэгдсэн урьдчилж төлсөн тооцоо болон урьдчилж орсон орлого дансыг 14.4 сая төгрөгийг хааж, устгах бичилт хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалт, УСНББОУС 6 “Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан”-гийн 45 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

4. Анхан шатны баримтыг хянан үзэхэд 8,148.4 сая төгрөгийн зардлын эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" журамтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

5. Бараа материалыг худалдан борлуулахдаа 3.0 сая төгрөгийн олз хүлээн зөвшөөрсөн.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тогтоолтой нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

6. Бүрэлдэхүүн нэгж Хэвлэх үйлдвэр болон Номын сан хариуцсан ахлах нягтлан бодогчийн эзэмшсэн үндсэн мэргэжил (бакалаврын диплом) нь “Эдийн засагч” байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д “мэргэжлийн нягтлан бодогч” гэж их, дээд сургууль, коллежийг нягтлан бодогчийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэргээр төгссөн хүнийг, 3.1.7-д “мэргэшсэн нягтлан бодогч” гэж мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан мэргэжлийн нягтлан бодогч, санхүүч, эдийн засагчийг гэж тодорхойлсон байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хэрэгжилтийг хангуулах албан шаардлага өгсөн.

7. Япон улсын Шима Секи компанитай 2016.7.27-ны өдөр байгуулсан тоног төхөөрөмж худалдан авах гэрээний дагуу 2016.9.20-ний өдөр хүлээн авч, акт үйлдсэн нэг бүр нь 18,000 ам долларын үнэтэй 4 ширхэг, нийт 72.000 ам.долларын хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохих зөвшөөрлийг авч, үндсэн хөрөнгийг бүртгэж авах, хөрөнгийн элэгдлийг УСНББОУС 17-д заасны дагуу тооцож, бүртгэх албан шаардлага өгсөн.

Аудитаар илэрсэн хууль, тогтоомж хэрэгжүүлж ажиллаагүй алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

- Сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого дансанд нийт 25,500 оюутанд хамаарах 8.026.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого болон авлагын үлдэгдэлд санамсаргүй түүврийн аргаар нийт 76 оюутны 90.0 сая төгрөгийн үлдэгдлийг тулган баталгаажуулж үзэхэд 24 сар ба түүнээс дээш насжилттай, сургуулиа төгссөн, сургуулиас гарсан, шилжсэн эсвэл сураггүй гэсэн төлөвтэй оюутанд хамаарах 8.6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн орлогыг урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн хэвээр байна. Түүвэрт хамрагдсан дансны нийт алдааны түвшин 9.0 хувь байгаа ба нийт олонлогт харьцуулан шилжүүлж тооцвол энэ алдаа нь 862.2 сая төгрөг болохоор байна.
- Хэвлэх үйлдвэрээс бүрэлдэхүүн сургуулиудад үзүүлсэн үйлчилгээ (Ном хэвлүүлсэн)-ний 355.6 сая төгрөгийн орлого болон бүрэлдэхүүн сургууль тус бүрийн зардал нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахдаа тохируулга хийж, орлого, зардлын устгах бичилтийг хийгээгүй.

Дараагийн аудитаар дээрх 2 асуудлыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Шинжлэх ухаан технологийн их сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан 2,943 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, 57 мэдээллийг хугацаа хоцроож нийт 3,000 мэдээлэл байршуулсан байна.

Хорин гурван бүрэлдэхүүн нэгжүүдээс төсөв гүйцэтгэлтэй холбоотой 963 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 1,275 мэдээлэл, бусад 762 мэдээлэл тус тус оруулсан байна.

## **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 220.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 192.5 сая төгрөгийн зөрчлийг арилгаж 87.4 хувийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй талаар зохистой тайлбарыг ирүүлсэн тул зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь гэж үзлээ.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

#### **2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

**3.1.1 Илрүүлэлт:** ШУТИС нь 2019 онд нийт 8 удаагийн нээлттэй тендер шалгаруулалт зарлан, худалдан авалт хийсэн байна. Тендерийн баримт бичгийг хянан үзэхэд 5 тендерийн гэрээг дүгнэсэн акт үйлдэж, тендерийн хавтаст хэрэгт хавсаргаагүй байна. Мөн худалдан авах ажиллагааны төсвийг Удирдах зөвлөлөөр хэлэлцэж баталдаг боловч тайлангаа дараа оны 3 сард дүгнэдэг байдал нь худалдан авалтад тавих дотоод хяналтын орчин сул хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 -д, “Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ. Үүнд: 49.2.10. гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичгийг хавсаргах”, ТБОНӨХБАҮХА хуулийн 49.5-д “Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнана” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.1.2 Эрсдэл:** Худалдан авалттай холбоотой аливаа зальт ажиллагааны эрсдэл үүсэх, хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулах.

**3.1.3 Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг тайлагнах, тендерийн баримт бичгийг иж бүрэн, зохистой бүрдүүлж, алдааг давтан гаргахгүй байхыг анхаарч ажиллах.

**3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрч байна. Цаашид давтан гаргахгүй, хуулийг хэрэгжүүлнэ.

#### 3.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

**3.2.1 Илрүүлэлт:** Тендерийн үнэлгээний хороонд тус байгууллагын Хөрөнгө оруулалт хангамжийн газрын эрх зүйн мэргэжилтэн (үндсэн ажилтан) нь “Монголын хуульчдын холбоо” ТББ-ыг төлөөлөн хараат бус гишүүнээр ажилласан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг

хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2.2** Эрсдэл: Дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх, үнэлгээ хорооны шийдвэр хараат байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх.

**3.2.3** Өгсөн зөвлөмж: ТБОНӨХБАУХА тухай хуулийг хэрэгжүүлж, дээрх алдааг давтан гаргахгүй байхыг анхаарч ажиллах.

**3.2.4** Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна. Цаашид давтан гаргахгүй, хуулийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.3 Дотоод аудиттай холбоотой асуудал**

**3.3.1** Илрүүлэлт: ШУТИС-ын Дотоод аудитын алба нь Хяналт, шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирлын харьяанд ажиллаж байгаа нь “бие даасан хараат бус байх” зарчмыг алдагдуулж байна. Энэ нь Засгийн газрын 2015 оны 483-р тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 3 дугаар зүйлд “Дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус...” байх тухай, мөн тус дүрмийн 7 дугаар зүйлд “Дотоод аудитын ... төлөвлөгөөг төсвийн захирагч батлах”... , Дотоод аудитын нэгжийн дарга асуудлыг ...төсвийн захирагчид танилцуулж тайлагнах...” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.3.2** Эрсдэл: Бие даасан хараат бус байх зарчим алдагдах, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх, хууль тогтоомжийг биелүүлэхгүй байх

**3.3.3** Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 483-р тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

**3.3.4** Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна. Хэрэгжүүлж ажиллана.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

**3.4.1** Илрүүлэлт: ШУТИС нь 2017 онд баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дагаж мөрддөг ба энэ хугацаанаас хойш гарсан хууль, тогтоомж, дүрэм журам, УСНББОУС-ын холбогдох өөрчлөлтүүдийг тусгаж, шинэчлээгүй байна. Тухайлбал:

- Бараа материалын хэсэгт бараа материал өртгөөс нь илүү үнээр худалдсан үед олз хүлээн зөвшөөрдөг.
- Төгссөн болон шилжсэн, гарсан оюутнуудын сургалтын төлбөрийн үлдэгдлийн дансны ангилал шилжүүлэх арга, аргачлалыг тусгаагүй байна.
- Нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулах, бичилт хийх заавар байхгүй байна.
- Үйлдвэрлэл эрхэлдэг байгууллага нь өртөг зардлын бүртгэлээ хөтлөх аргачлал, зааврын талаар тусгаагүй.
- Төсөл гэрээт ажлын зардлыг өртгийн объектоор нь зардлын зүйл тус бүрээр хуримтлуулан бүртгэх зааварчилгаа байхгүй. Эдгээр сул талууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.4.2** Эрсдэл: Дотоод хяналтын тогтолцоо сул байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;  
(САГ-2020/79/СТА-ТӨҮГ)

3.4.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ зохих шинэчлэлтийг хийж батлуулах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна. БСШУСЯ-наас 2020 онд нийт төрийн өмчит их, дээд сургуулиудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нэгдсэн байдлаар боловсруулж, нийтэд нь мөрдүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуулан, ажил хэрэг болгох ажлыг зохион байгуулж байна.

### **3.5 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал**

3.5.1 Илрүүлэлт: ШУТИС-ийн зарим оюутнуудын Боловсролын зээлийн сангаас хүлээн авсан оюутны хөгжлийн зээл, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж болох 1,601.1 сая төгрөгийн сургалтын төлбөрийн орлогыг БСШУСЯ-ны Сайдын нэгдсэн санхүүгийн тайланд устгах бичилт хийх зорилгоор Засгийн газрын тусгай сангаас санхүүжих гэсэн дансанд салгаж бүртгэж байгаа нь Засгийн газрын тусгай сангаас санхүүжсэн мэт буруу ойлголтыг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд төрүүлэхээр байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.5.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, тайлагналын тодорхойгүй байдал үүсэх

3.5.3 Өгсөн зөвлөмж: Боловсролын зээлийн сангаас орж ирсэн сургалтын төлбөрийн орлогыг Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэж, тайлагнах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ тусгаж, зөрчлийг дахин гаргахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код  | Балансын үзүүлэлт                  | 2018 оны 12-р сарын 31    | 2019 оны 12-р сарын 31    |
|-------------|------------------------------------|---------------------------|---------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>     | <b>43,092,244,700.95</b>  | <b>30,072,518,833.67</b>  |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>              | 34,413,101,034.06         | 24,656,956,730.88         |
| <b>312</b>  | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>  | 27,138,912,987.09         | 16,883,215,821.71         |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>                      | 27,034,375,272.99         | 16,776,506,554.07         |
| 31213       | Арилжааны банк дахь харилцах       | 27,034,375,272.99         | 16,776,506,554.07         |
| <b>3122</b> | <b>Гадаад валют</b>                | 104,537,714.10            | 106,709,267.64            |
| 31223       | Арилжааны банк дахь харилцах       | 104,537,714.10            | 106,709,267.64            |
| 31500       | Хадгаламж                          | 7,274,188,046.97          | 7,773,740,909.17          |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>                      | 6,015,220,489.48          | 2,864,310,711.69          |
| 33100       | Ажиллагчидтай холбогдсон авлага    | 4,725,000.00              | 2,975,000.00              |
| 33200       | Төлбөртэй үйлчилгээний авлага      | 2,333,949,657.25          | 2,247,072,827.01          |
| 33300       | Татаас, санхүүжилтийн авлага       | 2,639,119,167.56          | 2,820,000.00              |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>                | 1,037,426,664.67          | 611,442,884.68            |
| 3351        | Байгууллагаас авах авлага          | 685,045,486.87            | 282,791,851.55            |
| 3352        | Хувь хүмүүсээс авах авлага         | 352,381,177.80            | 328,651,033.13            |
| <b>34</b>   | <b>УРЬДЧИЛГАА</b>                  | 765,551,699.11            | 651,187,412.00            |
| 34600       | Урьдчилж гарсан зардал             | 88,402,780.00             | 259,469,188.00            |
| <b>3471</b> | <b>Урьдчилгаа тооцоо</b>           | 677,148,919.11            | 391,718,224.00            |
| 34711       | Бараа материал бэлтгэх урьдчилгаа  | 591,591,870.11            | 312,957,629.00            |
| 34712       | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа  | 76,607,249.00             | 78,437,185.00             |
| 34713       | Цалингийн урьдчилгаа               | 3,500,000.00              | -                         |
| 34714       | Томилолтын урьдчилгаа              | 5,449,800.00              | 323,410.00                |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>              | 1,898,371,478.30          | 1,900,063,979.10          |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>          | 1,362,251,907.19          | 1,353,648,636.50          |
| 35110       | Тусгай зориулалттай материал       | 1,361,305,171.19          | 1,352,732,310.00          |
| 35130       | Эм боох материал                   | 946,736.00                | 916,326.50                |
| 35300       | Бэлэн бүтээгдэхүүн                 | 12,261,855.00             | 44,678,591.00             |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>         | 523,857,716.11            | 501,736,751.60            |
| 35410       | Бичиг хэргийн материал             | 179,496,713.80            | 183,894,628.90            |
| 35420       | Нормын хувцас                      | 31,015,674.50             | 23,015,624.00             |
| 35430       | Сэлбэг хэрэгсэл                    | 5,522,955.00              | 10,904,110.00             |
| 35450       | Барилгын засварын материал         | 18,883,098.92             | 16,001,963.92             |
| 35460       | Хүнсний материал                   | 4,369,799.43              | 6,121,098.85              |
| 35470       | Бусад хангамжийн материал          | 284,569,474.46            | 261,799,325.93            |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b> | <b>100,987,721,264.19</b> | <b>112,188,477,070.34</b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>              | 100,987,721,264.19        | 112,188,477,070.34        |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                | 93,435,002,980.68         | 104,671,485,328.22        |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц     | 76,720,254,799.18         | 86,559,312,897.37         |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл              | (3,886,326,660.57)        | (5,944,474,889.92)        |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл             | 1,340,170,665.10          | 1,328,542,665.10          |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл              | (966,875,370.17)          | (1,053,970,456.97)        |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)  | 32,556,449,167.01         | 41,737,944,432.54         |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл              | (19,799,937,697.72)       | (23,444,353,280.46)       |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил        | 5,572,956,127.24          | 6,313,639,704.31          |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл              | (3,321,125,619.07)        | (3,754,170,883.10)        |
| 39213       | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс   | 7,609,200.00              | 128,415,550.00            |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө               | 237,037,486.92            | 275,836,025.92            |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл              | (166,530,836.87)          | (174,146,317.46)          |

ШУТИС-ийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|             |   |                                  |                                  |
|-------------|---|----------------------------------|----------------------------------|
| 39216       | Дуусаагүй барилга, байгууламж   | 2,818,202,419.54                 | 366,399,144.55                   |
| 39217       | Ном   | 2,323,119,300.09                 | 2,332,510,736.34                 |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>   | <b>7,552,718,283.51</b>          | <b>7,516,991,742.12</b>          |
| 39301       | Програм хангамж   | 1,394,892,643.56                 | 1,478,222,764.56                 |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл   | (1,047,672,900.05)               | (1,166,729,562.44)               |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө  | 7,205,498,540.00                 | 7,205,498,540.00                 |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b><u>144,079,965,965.14</u></b> | <b><u>142,260,995,904.01</u></b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b><u>10,273,209,522.13</u></b>  | <b><u>11,368,519,194.32</u></b>  |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | <b>10,206,110,999.37</b>         | <b>11,307,111,978.06</b>         |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>  | <b>319,907,767.34</b>            | <b>829,669,704.73</b>            |
| 41310       | Ажилчидтай холбогдсон өглөг   | 1,291,366.76                     | 613,802.00                       |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>  | <b>318,616,400.58</b>            | <b>829,055,902.73</b>            |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг  | 224,910,871.58                   | 740,117,073.73                   |
| 41362       | Хувь хүмүүст төлөх өглөг  | 93,705,529.00                    | 88,938,829.00                    |
| <b>414</b>  | <b>Урьдчилж орсон орлого</b>  | <b>9,886,203,232.03</b>          | <b>10,477,442,273.33</b>         |
| 41440       | Бусад урьдчилж орсон орлого   | 9,886,203,232.03                 | 10,477,442,273.33                |
| <b>42</b>   | <b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b>67,098,522.76</b>             | <b>61,407,216.26</b>             |
| <b>422</b>  | <b>Урт хугацаат зээл</b>  | <b>67,098,522.76</b>             | <b>61,407,216.26</b>             |
| <b>4222</b> | <b>Гадаад валют</b>   | <b>67,098,522.76</b>             | <b>61,407,216.26</b>             |
| 42230       | Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/                                   | 67,098,522.76                    | 61,407,216.26                    |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>133,806,756,443.01</u></b> | <b><u>130,892,476,709.69</u></b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | <b>133,806,756,443.01</b>        | <b>130,892,476,709.69</b>        |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 30,748,325,524.44                | 30,748,325,524.44                |
| 51101       | Өмч: - төрийн   | 30,748,325,524.44                | 30,748,325,524.44                |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | <b>41,942,633,877.44</b>         | <b>39,033,795,798.21</b>         |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн  | 37,079,912,486.61                | 40,234,606,250.47                |
| 51220       | Тайлант үеийн үр дүн  | 4,862,721,390.83                 | (1,200,810,452.26)               |
| 51300       | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 61,115,797,041.13                | 61,110,355,387.04                |
| <b>6</b>    | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b><u>144,079,965,965.14</u></b> | <b><u>142,260,995,904.01</u></b> |



## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

|             |   | /төгрөг/                 |                          |
|-------------|---|--------------------------|--------------------------|
| Дансны код  | Үзүүлэлт  | 2018 оны 12-р сарын 31   | 2019 оны 12-р сарын 31   |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                    | <b>53,486,875,467.79</b> | <b>57,813,285,242.01</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                | <b>49,787,084,571.76</b> | <b>56,729,173,641.54</b> |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                        | 49,677,210,271.76        | 56,599,924,141.54        |
| 120002      | Хүүгийн орлого  | 2,058,747,352.81         | 1,640,366,238.91         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                          | 47,505,429,394.95        | 54,820,608,753.63        |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                 | 35,953,856,448.14        | 38,195,185,229.73        |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                 | 6,563,070,378.25         | 7,401,177,668.09         |
| 1200044     | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих                           | 326,820,471.21           | 399,979,997.37           |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                         | 4,661,682,097.35         | 8,824,265,858.44         |
| 120005      | Түрээсийн орлого  | -                        | 138,949,149.00           |
| 120006      | Газрын тосны орлого                                       | 113,033,524.00           | -                        |
| <b>123</b>  | <b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b> | 109,874,300.00           | 129,249,500.00           |
| 123001      | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого                     | 109,874,300.00           | 129,249,500.00           |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                      | <b>3,699,790,896.03</b>  | <b>1,084,111,600.47</b>  |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                            | 1,976,784,595.00         | 725,561,890.47           |
| 131006      | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих                   | 1,976,784,595.00         | 725,561,890.47           |
| <b>1330</b> | <b>Төсвийн захирагчдаас</b>                               | 1,723,006,301.03         | 358,549,710.00           |
| 133004      | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт         | 1,441,285,191.03         | -                        |
| 133005      | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт     | 281,721,110.00           | 358,549,710.00           |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                        | <b>48,621,012,819.92</b> | <b>58,870,562,533.59</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                      | <b>48,568,765,743.92</b> | <b>58,870,562,533.59</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                    | 47,488,808,817.19        | 58,140,007,130.26        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                  | 27,976,124,810.49        | 31,242,184,509.82        |
| 210101      | Үндсэн цалин  | 23,700,026,708.49        | 25,925,532,421.22        |
| 210102      | Нэмэгдэл  | 4,276,098,102.00         | 5,316,652,088.60         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>     | 3,359,412,207.82         | 3,925,319,690.17         |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 2,250,213,990.30         | 2,699,973,517.91         |
